



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 4/59

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 15.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 301 дүгээр тушаал, тус газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газраас хэрэгжүүлж буй "Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (<https://www.e-mongolia.mn>), "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (<https://www.erp.e-mongolia.mn>)" төслийн хүрээнд Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймгуудын "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн ажилтнуудад тус системүүдийг ашиглах сургалт хийх ажлаар тус газрын Төслийн нэгжийн ажилтан О.Ариунтуяа, О.Төгөлдөр, Б.Хишигжаргал нарыг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд, Архангай, Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудын "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн ажилтнуудад тус системүүдийг ашиглах сургалт хийх ажлаар тус газрын Төслийн нэгжийн ахлагч Л.Энхбат, төслийн нэгжийн ажилтан Б.Батзул нарыг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 26-ны өдрүүдэд тус тус томилон ажиллуулсугай.

2. Томилолтоор ажиллах удирдамжийг нэгдүгээр, томилолтын зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Томилолтоор ажилласан тухай үр дүнгийн тайланг тус газрын удирдлагад зохих журмын дагуу танилцуулахыг Төслийн нэгжийн ахлагч Л.Энхбат, төслийн нэгжийн ажилтан Б.Батзул, О.Ариунтуяа, О.Төгөлдөр, Б.Хишигжаргал нарт даалгасугай.


4. Томилолтоор ажиллахад шаардагдах 6,350,938 /Зургаан сая гурван зуун тавин мянга есөн зуун гучин найм/ төгрөгийг зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /О.Наранбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЧИНБАТ

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн
газрын даргын 2020 оны 65 дүгээр сарын 05-ны
өдрийн 1/19 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Тус газраас Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (<https://www.e-mongolia.mn>), “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (<https://www.erp.e-mongolia.mn>)” төслийн хүрээнд Баруун бүсийн 8 аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн ажилтнуудад тус системүүдийн сургалт хийх.

Хоёр. Хамрах хүрээ

Томилолтоор ажиллах албан тушаалтан нь дараах Баруун бүсийн 8 аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн ажилтнуудад системийн нээлтийн ажиллагаа болон тус системүүдийг ашиглах сургалт хийнэ. Үүнд:

1-р баг /О.Ариунтуяа, О.Төгөлдөр, Б.Хишигжаргал 2020.05.11-2020.05.25/

1. Өвөрхангай аймаг
2. Баянхонгор аймаг
3. Говь-Алтай аймаг
4. Ховд аймаг

2-р баг / Л.Энхбат, Б.Батзул 2020.05.11-2020.05.26/

1. Архангай аймаг
2. Завхан аймаг
3. Увс аймаг
4. Баян-Өлгий аймаг

Гурав. Арга, хэмжээ

1. “Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (<https://www.e-mongolia.mn>), (<https://www.operator.e-mongolia.mn>) –ийн сургалт хийх.
2. “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (<https://www.erp.e-mongolia.mn>)” -ийн сургалт хийх.
3. Төвийн бүсийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн ажилтнуудад Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн
газрын даргын 2020 оны 05 дүгээр сарын 05 -ны
өдрийн А/59 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

1-р баг: Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймаг

№	Гишүүд	Аймаг	Зам хоногийн зардал	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал
1	Багийн ахлагч О.Ариунтуяа Багийн гишүүн О.Төгөлдөр Багийн гишүүн Б.Хишигжаргал	Өвөрхангай	14,000*3хүн	3	126,000.0
		Баянхонгор	14,000*3хүн	3	168,000.0
		Говь-Алтай	14,000*3хүн	4	168,000.0
		Ховд	14,000*3хүн	4	168,000.0
Нийт /₮/				15	630,000

№	Гишүүд	Аймаг	Байрны зардал	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал
2	Багийн ахлагч О.Ариунтуяа Багийн гишүүн О.Төгөлдөр Багийн гишүүн Б.Хишигжаргал	Өвөрхангай	36,000*3хүн	3	324,000
		Баянхонгор	36,000*3хүн	3	432,000
		Говь-Алтай	36,000*3хүн	4	432,000
		Ховд	36,000*3хүн	4	432,000
				15	1,620,000

ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

2-р баг: Архангай, Завхан, Увс, Баян-Өлгий аймаг

№	Гишүүд	Аймаг	Зам хоногийн зардал	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал
1	Багийн ахлагч Л.Энхбат Багийн гишүүн Б.Батзул	Архангай	14,000*2хүн	3	84,000.0
		Завхан	14,000*2хүн	4	112,000.0
		Увс	14,000*2хүн	4	112,000.0
		Баян-Өлгий	14,000*2хүн	5	140,000.0
Нийт /₮/				16	448,000

№	Гишүүд	Аймаг	Байрны зардал	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал
2	Багийн ахлагч Л.Энхбат Багийн гишүүн Б.Батзул	Өвөрхангай	36,000*2хүн	3	216,000
		Баянхонгор	36,000*2хүн	4	288,000
		Говь-Алтай	36,000*2хүн	4	288,000
		Ховд	36,000*2хүн	5	360,000
				16	1,152,000

1-р баг

№	Хаанаас	Хаана	Явах зай/км/	Шатахууны зардал
1	Улаанбаатар	Өвөрхангай	450	169,875.0
2	Өвөрхангай	Баянхонгор	220	83,050.0
3	Баянхонгор	Говь-Алтай	390	147,225.0
4	Говь-Алтай	Ховд	455	171,762.5
5	Ховд	Улаанбаатар	1505	568,137.5
Нийт			3020	1,140,050

2-р баг

№	Хаанаас	Хаана	Явах зай/км/	Шатахууны зардал
1	Улаанбаатар	Архангай	475	179,312.5
2	Архангай	Завхан	550	207,625.0
3	Завхан	Увс	550	207,625.0
4	Увс	Баян-Өлгий	320	120,800.0
5	Баян-Өлгий	Улаанбаатар	1710	645,525.0
Нийт			3605	1,360,887.5
Бүгд үнэ			6625	2,500,937.5
Бүгд нийт үнэ ₮				6,350,938